

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 65.130

Ноос, ноолуур. Түүхий эд бэлтгэл. Хонины ноос. Техникийн шаардлага	MNS 0033 : 2007 MNS 0033 : 2001-ийн оронд
Textiles. Grease wool. Technical specification	

Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 61 дүгээр тогтоолоор батлав.

Энэ стандарт нь 2008 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь хонины нарийн, нарийвтар, бүдүүвтэр, бүдүүн ноосыг бэлтгэж, хүлээн авахад хамаарна.

2. Нэр томъёо, тодорхойлолт

2.1 Үргэлж ноос (Fleese wool) - багц, туг үс нь өөр хоорондоо нягт хэлхэлдсэн ноос;

2.2 Багц үс (Bundle hair) - нэг төрлийн нарийн, урт, жигд ширхэгтээс тогтсон, үзүүр, уг нь тэгш хэлбэртэй хэсэг ноос;

2.3 Туг үс (Tufty hair) - ноолуур, завсрын үс, сор, хялгас агуулсан, уг нь өргөн, үзүүр нь нарийн хэсэг ноос;

2.4 Бут ноос (Scrub wool) - жижиг, хэсэг хэсгээрээ салсан ноос;

2.5 Нарийн ноос (Fine wool) - Багц үс нь дан ноолуураас тогтсон, нарийн, зөөлөн, угаасаа үзүүр хүртэл жигд атираатай, бат бэх, хэвийн зунгагтай ноос;

2.6 Нарийвтар ноос (Semi-fine wool) - Багц үс нь ноолуур, завсрын үснээс тогтсон, жигд долгиолсон атираатай, нарийн, уян хатан, бат бэх, багц үсний үзүүр нь хуурайвтар, хэвийн зунгагтай ноос;

2.7 Бүдүүвтэр ноос (Semi-coarse wool) - Ноолуур, завсрын үс, сор холилдсон, жигд биш, урт, хэвийн зунгагтай, уян хатан, бат бэх, үргэлж ноосны үндсэн хэсэгт хялгасгүй, хонго, хээлүүр, хүзүүний ноосонд хялгас бага зэрэг тохиолдох ноос;

2.8 Бүдүүн ноос (Coarse wool) - Ноолуур, завсрын үс, сор, хялгаснаас тогтсон, туг хэлбэртэй, бат бэх, хэвийн зунгагтай, төрөл бүрийн үсний харьцаа харилцан адилгүй ноос;

2.9 Хурганы бүдүүвтэр ноос (Lamb's coarser wool) - 5-аас 6 сартай хурганаас хяргаж авсан, бүдүүвтэр ноосны шаардлага хангасан ноос;

MNS 0033 : 2007

2.10 Хурганы бүдүүн ноос (Lamb's coarse wool) - Туг үсний үзүүр нь бага зэрэг цагирагласан, туг үс нь өөр хоорондоо холбогдоогүй, зөөлөн, бохирдлого багатай, зунгаг ихтэй, бутархай байдалтай, бүдүүн ноосны шаардлага хангасан ноос;

2.11 Шарласан үргэлж ноос (Stained fleeces wool) - Үргэлж ноосны талбайн болон багц, туг үсний уртын гуравны нэгээс дээш хувь нь үндсэн өнгөө алдаж шарласан ноос;

2.12 Шарласан бутархай ноос (Stained wool) - Малын хашаа, хороонд унасан, шивх, бууц, шавхайгаар бохирдсон бут ноос;

2.13 Гэмтэлтэй ноос (Damaged wool) - Хагтай, хэвийн өнгөө алдаж, ширхэг нь дундуураа буюу хоёр үзүүрээрээ нарийсаж, тасархайтсан ноос;

2.14 Бутархай ноос (Opened wool) - Хонины хөл, хээлүүр, толгойн хэсгийн багц, туг бут ноос;

2.15 Даахь ноос (Matted wool) - Ноосны багц, туг үснүүд өөр хоорондоо ширэлдэж, гараар урж таслахад хялбар биш, сэмрэхгүй бут хэсгээр тасарч урагдах ноосыг хэлнэ.

3. Ангилал

3.1 Хонины ноосыг дараах байдлаар ангилна.

3.1.1 Нэр төрлөөр нь:

- а/ Нарийн;
- б/ Нарийвтар;
- в/ Бүдүүвтэр;
- г/ Бүдүүн.

3.1.2 Өнгөөр нь:

- а/ Цагаан;
- б/ Өнгийн /хар, бусад/.

3.1.3 Чанараар нь:

Нарийн, нарийвтар, бүдүүвтэр ноосыг,

- а/ Нэгдүгээр анги;
- б/ Хоёрдугаар анги;

Бүдүүн ноосыг

- а/ Нэгдүгээр анги;
- б/ Хоёрдугаар анги;
- в/ Гуравдугаар анги.

3.1.4 Гадаад байдал, бохирдолтоор нь:

- а/ Үргэлж (хэвийн, шарласан, гэмтэлтэй);
- б/ Доод ангийн ноос (бутархай, шарласан, даахь) гэж ангилна.

4. Техникийн шаардлага

4.1 Хэвийн үргэлж ноосон дахь хялбар ялгагдах ба хялбар ялгагдахгүй хог, зангуу, шивээ, өргөс болон бусад бохирдлогын хэмжээ нь нарийн, нарийвтар үргэлж ноосны нийт талбайн болон жингийн 10 %-иас, бүдүүн, бүдүүвтэр ноосонд 5 %-иас тус тус ихгүй байна.

4.2 Тосон будаг, замын хараар тэмдэглэсэн ноосыг үргэлж ноосноос салгаж авсан байна.

4.3 Нарийн, нарийвтар ноосны хэвийн чийглэг (15 ± 1)%, бүдүүн, бүдүүвтэр ноосны хэвийн чийглэг (12 ± 1)% байна.

4.4 Хонины ноосны өнгө 1 дүгээр хүснэгтэд заасан тодорхойлолтод тохирч байна.

1 дүгээр хүснэгт

Д/д	Өнгө	Тодорхойлолт
1	Цагаан	Үргэлж ноос нь гадна, дотор талдаа хэвийн цагаан
2	Өнгийн	Цагаан бусад өнгийн ноостой холилдсон

4.5 Нарийн, нарийвтар, бүдүүвтэр ноосны анги, чанарын үзүүлэлт 2 дугаар хүснэгтэд заасантай тохирч байна.

2 дугаар хүснэгт

Д/д	Хонины үүлдэр, ноосны төрөл	Чанарын анги	Ширхэгтийн		Үргэлж ноосны үндсэн шаардлага
			дундаж нарийн, мкм	дундаж урт, мм /дээш/	
1	Хангай үүлдрийн хонины нарийн ноос	I	23,0 хүртэл	65-75	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний атираа нь жигд зөв хэлбэртэй, 1 см-д 5-6 атираатай өнгөлөг зөөлөн, цагаан өнгөтэй, хэвийн зунгагтай байна.
		II	23,1-25,0	70-75	Үргэлж ноосны үзүүр нь хоорондоо сул барьцалдсан, шовх хэлбэртэй, хуурайвтар, багцын үзүүрээс уг хүртэл жигд атираатай, хэвийн зунгагтай байна.
2	Орхон үүлдрийн хонины нарийвтар ноос	I	25,1-29,0	70	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний ширхэг нарийн, жигд, бат бэх, хэвийн зунгагтай байна.
		II	29,1-31,0	75	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний ширхэг нарийн, жигд, багц үсний үзүүр хуурайвтар байна.

3	Тал нутгийн цагаан үүлдрийн хонины нарийвтар ноос	I	25,1-29,0	75	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний үзүүрээс уг хүртэл долгиолсон жигд атираатай, бат бэх, уян хатан, нарийн, жигд, хэвийн зунгагтай байна.
		II	29,1-31,0	80	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний үзүүр хуурайвтар, нарийн, жигд байна.
4	Ерөө үүлдрийн хэсгийн хонины нарийвтар ноос	I	25,1-31,0	80	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний үзүүрээс уг хүртэл долгиотсон атираатай, өнгөлөг гялалзсан, бат бэх, уян хатан, хэвийн зунгагтай байна.
		II	31,1-34,0	85	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний үзүүр хуурайвтар, нарийн байна.
5	Жаргалант үржлийн хэсгийн хонины нарийвтар ноос	I	25,1-31,0	55	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний үзүүрээс уг хүртэл жигд биш атираатай, нарийн, багц үсний үзүүр хуурайвтар, зунгаг багатай байна.
		II	31,1-34,0	65	Үргэлж ноосны үндсэн хэсгийн багц үсний үзүүрээс уг хүртэл жигд биш атираатай, нарийн, бат бэх, уян хатан байна.
6	Байдраг, Говь-Алтай үүлдрийн хонины бүдүүвтэр ноос	I	26,1-29,0	130	Үргэлж ноосны үндсэн хэсгийн туг үс нь ноолуур, завсрын үс, нарийн урт сортой, жигд, гялалзсан туяатай, торгомсог зөөлөн, бат бэх, хэвийн зунгагтай, тод цагаан өнгөтэй байна. Үргэлж ноос нь хялгасгүй байна.
		II	29,1-31,0	175	Үргэлж ноос нь ноолуур, завсрын үс, бүдүүн сортой, бат бэх, хэвийн зунгагтай, хонго, хээлүүр, хүзүү, гуяны ноос үзэгдэх төдий хялгастай байна.

7	Баяд үүлдэр, Тамир үүлдрийн хэсэг, Сартуул, Дархад, омгийн хонины бүдүүвтэр ноос	I	29,0- 34,0	98	Үргэлж ноосны туг үс нь ноолуур, завсрын үс, бүдүүн богино сортой, бат бэх, хэвийн зунгагтай, бүдэг цагаан өнгөтэй, бага зэргийн хялгастай байна.
8	Торгууд үүлдрийн хэсгийн хонины бүдүүвтэр ноос	I	29,1- 31,0	97	Үргэлж ноосны туг үс нь ноолуур, завсрын үс, нарийн урт сортой, бат бөх, хэвийн зунгагтай, хялгасгүй, цайвар, бор өнгөтэй байна.
		II	29,0- 34,0	97	Үргэлж ноос нь ноолуур, завсрын үс, бүдүүн сортой, бат бэх, хэвийн зунгагтай, үзэгдэх төдий хялгастай, хүрэн бор өнгөтэй байна.
9	Хурганы бүдүүвтэр ноос	I	25-30,0	60	Үргэлж ноосны туг үс нь ноолуур, завсрын үс, нарийн сортой, гялалзсан туяатай, торгомсог, зөөлөн, бат бэх, тод цагаан өнгөтэй, туг үсний үзүүр цагирагласан, байна.
		II	28,0- 30,0	55	Үргэлж ноосны туг үс нь ноолуур, завсрын үс, нарийн сортой, зөөлөн, бат бэх, хар, бор, хүрэн өнгөтэй, туг үсний үзүүр цагирагласан байна.

4.6 Бүдүүн ноосны анги, чанарын үзүүлэлт 3 дугаар хүснэгтэд заасантай тохирч байна.

3 дугаар хүснэгт

Д/д	Чанарын анги	Ширхэгтийн дундаж нарийн, мкм	Үргэлж ноосны үндсэн шаардлага
1	I	32,5-34,2	Үргэлж ноосны туг үс ноолуур, завсрын үс, нарийн сортой, үзэгдэх төдий хялгастай, 60 %-иас дээш ноолууртай байна.
2	II	34,3-39,0	Үргэлж ноосны туг үс нь ноолуур, завсрын үс, бүдүүн сортой, 57,0 %-иас дээш ноолууртай байна.
3	III	39,1-ээс дээш	Нэг ба хоёрдугаар ангийн шаардлага хангаагүй, 40 %-иас ихгүй ноолууртай байна.

ТАЙЛБАР:1 Үргэлж ноосны үндсэн хэсгийн талбайн 55 %-иас багагүй хэмжээтэй ноосоор ангийг тогтооно.

ТАЙЛБАР:2 Ноосны уртыг багц, туг үсний атирааг сунгахгүйгээр мм-ийн хуваарьтай шугамаар хэмжинэ.

5. Шалгаж, хүлээн авах

5.1 Хонины ноосны нийт жингийн 10 %-д чанарын шалгалт хийж хүлээн авна. Шаардлагатай гэж үзвэл 100 %-ийн шалгалт хийнэ.

5.2 Хүлээн авч буй ноосны анги, чанарын аль нэг үзүүлэлт тухайн ангийн чанарын шаардлага хангахгүй байвал уг ноосыг дараагийн доод ангид оруулна.

5.3 Ноосны анги, чанарын талаар гарсан маргааныг хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэнэ.

5.4 Хонины ноосны чанарыг тодорхойлохдоо дараах стандартыг мөрдөнө. Үүнд:

- 1) MNS 2951:2007 Ноос, ноолуур. Шинжилгээнд дээж авах арга;
- 2) MNS 4054:2007 Ноос, ноолуур. Урт тодорхойлох графикайн арга;
- 3) MNS 1000:2007 Ноос, ноолуур. Бичил дурангаар нарийн тодорхойлох арга;
- 4) MNS 1027:2007 Ноос, ноолуур. Хаг, хогт хольц тодорхойлох арга;
- 5) MNS 380:2007 Ноос, ноолуур. Чийглэг тодорхойлох арга;
- 6) MNS 2949:2001 Ноосны бүрэлдэхүүн тодорхойлох арга.
- 7) MNS 3961:2007 Ноос, ноолуур. Урт тодорхойлох тоолох арга.

6. Савлах, хаяглах, хадгалах, тээвэрлэх

6.1 Үргэлж ноосыг сэгсэрч цэвэрлэн, ангилсны дараа багц, туг үсний үзүүрийг гадагш харуулан дэлгэж, хоёр хажууг дотогш нь ноосны талбайн өргөний гуравны нэгийн хэмжээгээр нугалаад толгой, сүүл талаас нь хуйлж эвхэнэ. Ноосыг өөрөөр эвхэхийг хориглоно.

6.2 Хонины ноосыг “Ноос, ноолуур. Савлах, хаяглах, хадгалах журам MNS 0215 : 2007”-ын шаардлагын дагуу савлаж, хаяглаж, хадгалж, тээвэрлэнэ.

6.3 Шарласан, бутархай, даахь ноосыг тусад нь савлана.

ТӨГСӨВ.